



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ IV УЛИРЛЫН БАЙДЛААР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 221 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 6 хувиар тус тус нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу тэтгэвэр авагчдын тэтгэврийг шинээр тогтоох, тэтгэврийг өөрчлөн тогтооход хяналт тавин үйл ажиллагаагаа чиглүүлэн, нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний стандарт, чанар, хүртээмж, үйлчилгээний соёл, сахилга хариуцлагатай, нийгмийн даатгалын байцаагчийн ёс зүйг чандлан сахих, ажлын цаг ашиглалт, ажлын үр дүнг дээшлүүлэх тал дээр анхаарч, Нийгмийн даатгалын тухай хуулийн хүрээнд бодлогын баримт бичгийг стандартын дагуу гарган тайлагнах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах үүргийг гүйцэтгэн ажилласан.

Санхүү бүртгэлийн талаар

НДЕГГазрын даргын тушаалаар баталсан үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны жилийн төсөв 2,045.7 сая төгрөгийг сар бүр зориулалт, хөтөлбөр арга хэмжээний дагуу зарцуулан ажиллах зорилт тавин ажиллаж, нийт 2,014.6 сая төгрөгийг үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулж 31.1 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж ажилласан.

Нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын Төрийн сан, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Голомт банк, Хаан банкны дансанд орж ирсэн шимтгэлийн орлого 760,610.3 сая төгрөгийг НДЕГ-ын төвлөрсөн санд цаг тухай бүрт нь бүрэн төвлөрүүлсэн.

2025 онд батлагдсан төсвийн хуваарийн дагуу Тэтгэврийн даатгалын сангийн зарлага 269,955.2 сая төгрөг батлагдсанаас 267,018.0 сая төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 15075.9 сая төгрөг батлагдсанаас 15075.9 сая төгрөгийн, YOMШӨ сангийн зардал 2133.9 сая төгрөг батлагдсанаас 1694.9 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 7798.4 сая төгрөг батлагдсанаас 7798.4 сая төгрөг зарцуулж нийт 3376,2 сая төгрөг хэмнэгдэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн батлагдсан хуваарийн дагуу зардлыг зүйл зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. Ажилгүйдлийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсөвт багтаан зарцуулж байгаа боловч төсөв хүрэлцэхгүй байгаа шалтгаанаар 1,9 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгогдохгүй буюу ажилгүйдлийн тэтгэмжийн өглөг үүсч байна. Энэ талаар НДЕГ-ын Бодлогын Хэрэгжилт, Судалгааны Газарт төсөвт тодотгол хийлгэх, нэмэлт санхүүжилт авах саналаа хүргүүлэн ажилласан.

Сангийн яамнаас үйл ажиллагааны зардалд батлагдсан жилийн төсөв 2,045.7 сая төгрөгийг сар бүр зориулалт, хөтөлбөр арга хэмжээний дагуу зарцуулан ажиллах зорилт тавин ажиллаж, нийт 2,014.6 сая төгрөгийг үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулж 31.1 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж ажилласан. Нийгмийн даатгалын сангуудын тайлан гаргах, бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор тухайн ажил хариуцсан байцаагч, сан хариуцсан мэргэжилтэн нартай хамтран тооцоо нийлэх, тайлан гаргах хугацааг тусгаж тайлангийн хуваарь гарган, хуваарийн дагуу ажилладаг. Сангийн тайланг чанартай, цаг хугацаанд нь үнэн зөв гаргахад анхаарч ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон 2025 оны 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн. Сар бүрийн 2-ны дотор сангийн болон байгууллагын санхүүгийн төсвийн



гүйцэтгэлийн мэдээ, сангийн авлага өглөгийн мэдээ, харилцах дансны үлдэгдлийн мэдээ, тэтгэвэр тэтгэмж авагчдын тооны мэдээ, харилцах дансны нэгдсэн товчооны мэдээ зэрэг 8-н төрлийн мэдээг бэлтгэн гаргаж НДЕГГазарт хүргүүлэн ажиллаж ажилласан.

Үндсэн хөрөнгийн болон эд хөрөнгийн жилийн эцсийн дотоод тооллого хийх ажлыг газрын даргын баталсан бүрэлдэхүүнээр хэрэгжүүлж тайланг удирдлагад танилцуулж, дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаа.

Тооллогоор 465 ширхэг 2,678.6 сая төгрөгийн өртөгтэй, 500,2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 2,178.4 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг тоолон баталгаажуулж ажилтан албан хаагчдын картыг шинэчлэн кодлуулж ажиллалаа. Хагас жилийн тооллогоор 14 ширхэг элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9.4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг актлах, 133 ширхэг 85.5 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн ашиглалтын хугацаа сэргээх хүсэлтийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулж удирдлагад танилцуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн ажиллалаа. ТӨБЗГазраас ирсэн шийдвэрийн дагуу хөрөнгийг актлах болон ашиглалтын хугацаа сэргээх бүртгэлийг хийж гүйцэтгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар үйл ажиллагааны зардлын төсвийн гүйцэтгэлд 4 зөвлөмж, Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлд 1 зөвлөмж нийт 5 зөвлөмж авсан. Зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж гүйцэтгэлийг аудитын байгууллагад хүргүүлэн ажиллаа.

Харилцагч арилжааны банктай байгуулсан ерөнхий гэрээний зүйл заалтын дагуу хамтран ажиллаж, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн ажиллаа.

Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлогыг бүртгэх, тэтгэвэр тэтгэмжийн олголтын файл, жагсаалт үүсгэх тухай бүртээ цахим мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэн, хяналт тавьж ажиллаж байна. Харин АТМ, мобайл банкаар орлого хийгдэж буй тохиолдолд гүйлгээний утга тодорхой бус, нэр регистрийн дугаар буруу бичигдсэн зэргээс шалтгаалан нэр тодорхойгүй орлогоор бүртгэх, бусад авлага, өглөг нэмэгдэх хандлагатай байгааг анхаарч НББ-ийн алдаа залруулга гаргахгүй ажиллахад анхаарч байна.

2024 оны 01 сараас эхлэн Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын хүрээнд 2025 оны санхүүгийн тайланг гарган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд НДЕГ-ын СБГ-ын зохион байгуулж буй ZOOM уулзалт, сургалтад тухай хамрагдаж, өгсөн үүрэг чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын сангуудын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг шинэ системд бүртгэн ажиллаж байна.

Тэтгэвэр, тэтгэмжийн олголтын жагсаалт, файл бэлтгэхдээ сард олговол зохих дүнгээр бэлдсэн эсэх, тэтгэмжийн жагсаалтад байгууллагын нэхэмжлэлийн дүн, дансны дугаар зөв эсэхийг тодруулж шалган анхан шатны баримтын бүрдлийн ханган тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг хийж байна. Сангийн болон үйл ажиллагааны тайлангаар гарсан өглөг авлагыг улирал бүр тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлангийн хаалтыг тухай бүрд нь хийж байна.

Банкнүүдаар хийгдсэн сангийн орлого зарлагын гүйлгээний талаар

Монгол улсын Сангийн сайд, Хөдөлмөр Нийгэм хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246/A/245 тоот хамтарсан тушаалаар баталсан “Маягт журам батлах тухай”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн



А/65 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг тус тус мөрдлөг болгон баримтлан ажилласан.

SICOS программаас банкны хуулгаа татан Төрийн сан, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Голомт банк, Хаан банкаар орж ирсэн сайн дурын болон ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээллийг банкны хуулгатай тулган мэдээллийн санг бүрдүүлэн цахим баазыг бий болгон ажиллаж байна.

Нэр, регистр тодорхойгүй гүйлгээг банкны данс эзэмшигчийн жагсаалт болон мэдээллийн сангаас шүүлт хийх, банкинд жагсаалт хүргүүлэн мэдээлэл солилцох ажлыг хийж хэрэгжүүлэн ажил олгогч болон даатгуулагчийн нэр дээр залруулан бүртгэж байна.

Арилжааны банкуудаас харилцахын чөлөөт үлдэгдэлд тооцох хүүг “Хамтран ажиллах гэрээ”-нд заасны дагуу Капитрон, Төр, Голомт, Худалдаа хөгжил, ХААН банкуудаас нэхэмжилэн авч, тооцоо нийлэн холбогдох сангийн харилцах дансуудад төвлөрүүлэн ажиллалаа.

НДЕГ-тай арилжааны банкуудын байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу тус газрын 65 данс байрших арилжааны банкттай батлагдсан журмын дагуу бүртгэлтэй цахим хаягаар дамжуулан төлбөр тооцоог хийж байна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээ, тайлан гаргах ажлын хүрээнд арилжааны банкнуудаас ирсэн төвлөрсөн сангийн хуулгыг үнэн зөв бүртгэж, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 2-ны өдөр цаг хугацаанд нь үнэн зөв гарган цахимаар хүргэн ажиллав.

Илүү төлсөн шимтгэлийн буцаалтыг даатгуулагч тус бүрээр хянаж 145.4 сая төгрөгийн буцаан олголтыг олгосон

Нийгмийн даатгалын сангийн бүх төрлийн дансуудаас цахимаар гүйлгээ хийхдээ төвлөрсөн орлогын дансыг буруу сонгосноос залруулгын гүйлгээ их гарч байгааг залруулж, Чингэлтэй дүүргийн НДГазрын пэйж хуудсан дээр харилцах дансны дугаарын жагсаалтыг шинэчлэн тавьж, ажил олгогч байгууллагуудын ня-бо нарт заавар зөвлөмж мэдээлэл өгч ажиллалаа.

Даатгалын сангуудаас иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж олгох ажлын хүрээнд

“Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Анхан шатны баримтыг үндэслэн ажил олгогч, даатгуулагчдад арилжааны 5 банкны 20 харилцах дансаар тэтгэвэр, тэтгэмж, YOMШӨ, ажилгүйдлийн тэтгэмжийг шилжүүлж, дансны хуулга, үлдэгдлийг тулган нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн цахим санд бүртгэн ажиллав.

Сангийн зардал 3.3 тэрбум төгрөгийн хэмнэгдэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн батлагдсан хуваарийн дагуу зардлыг зүйл зориулалтын дагуу зарцуулан ажилласан. Ажилгүйдлийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсөвт багтаан зарцуулж байгаа боловч төсөв хүрэлцэхгүй байгаа шалтгаанаар 1,9 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгогдохгүй буюу ажилгүйдлийн тэтгэмжийн өглөг үүсч байна. Энэ талаар НДЕГ-ын Бодлогын Хэрэгжилт, Судалгааны Газарт төсөвт тодотгол хийлгэх, нэмэлт санхүүжилт авах саналаа хүргүүлэн ажилласан.

Нийгмийн даатгалын сангийн зарцуулалтыг харуулбал :

/ сая төгрөгөөр /



№	НД-ын сан	Сангийн зардлын төлөвлөгөө	Сангийн зардлын гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт	Хувь
1	Тэтгэвэр	269,955.2	267,018.0	2,937.2	98,9
2	Тэтгэмж	15,075.9	15,075.9	0	100,0
3	ҮОМШӨД	2,133.9	1,694.9	439.0	79.4
4	Ажилгүйдэл	7,798.4	7,798.4	0	100
Нийт дүн		294,963.4	291,587.2	3,376.2	98,9

Сангийн бусад өглөг, авлагын талаар (1218, 3303 тоот данс)

Тэтгэвэр, тэтгэмжийн олголтын жагсаалт, файл бэлтгэх үед тухай банкны олгох тэтгэврийн сард олговол зохих дүнгээр бэлдсэн эсэхийг мөн тэтгэмжийн жагсаалтаар тухайн байгууллагын нэхэмжлэлийн дүн, дансны дугаар зөв эсэхийг тодруулж шалгасны дараа гүйлгээ хийн ажиллаж байна.

НББ-ийн бүртгэлийн бичилтээр даатгуулагч иргэд болон ажил олгогчийн нэр дээр шууд авлага үүсгэж бүртгэхгүй байх тал дээр анхаарч ЗХХэлтэстэй хамтран ажиллаж байна. Арилжааны банкуудад мэйл хаягаар хүснэгтийн дагуу нэр тодорхойгүй орлого, зарлагын гүйлгээг тодруулан тухай бүрт нь бүртгэлийг үнэн зөв хөтлөх талаар анхаарч ажиллаж байна.

Илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг төлүүлэхээр улсын байцаагчийн акт тавигдаж, төлбөрийг харилцах дансанд төлүүлэх ажил гүйлгээг бусад авлага/1218/ дансаар бүртгэдэг. Тухайн илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн авлагыг сан тус бүрээр, байгууллага, хувь хүнээр нь салган бүртгэж байна.

Ажил олгогч байгуулагад ХЧТА-ны болон Жирэмсэн амаржсны тэтгэмж илүү олгогдсон тохиолдолд тухайн ажил олгогчоос авлагаар бүртгэлд тусгаж тооцоо нийлэн албан бичиг хүргүүлж харилцах дансанд төлүүлж байна. 2024 оны жилийн эцсийн тайлангаар тэтгэврийн даатгалын сан 281.2 сая төгрөгийн авлагатай гарснаас 2025 онд 37.2 сая төгрөгөөр нэмэгдэж 95.2 сая төгрөгөө буурч 223.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тэтгэмжийн даатгалын сан 23.5 сая төгрөгийн авлагатай гарснаас 2025 онд 26.9 сая төгрөгөөр нэмэгдэж 22.6 сая төгрөгөөр барагдаж нийт 27.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Харин ажилгүйдлийн даатгалын сангийн хувьд 2024 оны жилийн эцсийн тайлангаар 70.5 сая төгрөгийн авлагатай гарснаас 24.2 сая төгрөгийн авлага нэмэгдэж, 11.8 сая төгрөгийн авлага барагдаж 82.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна. Эдгээр авлагыг барагдуулах, бууруулах, тооцоо нийлэх ажлыг 2025 оны турш хийж хэрэгжүүлээ.

Сарын мэдээ болон тайланг гарсны дараа шинжилгээ хийж, сан тус бүрийн зарлагын дүнг өмнөх сарынхаас өссөн буурсан зардлыг тэтгэвэр, тэтгэмж бодсон бүртгэл журналын бичилтийг тулган шалгаж байна.

Үйл ажиллагааны зардлын төсөв болон гүйцэтгэлийн талаар

Сангийн яамнаас үйл ажиллагааны зардалд батлагдсан жилийн төсөв 2,045.7 сая төгрөг. Үйл ажиллагааны зардлын төсвийг сар бүр зориулалт, хөтөлбөр арга хэмжээний дагуу



зарцуулан ажиллаж байна. 2025 онд урсгал үйл ажиллагааны зардалд батлагдсан 2,045.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 20,044.5 сая төгрөг зарцуулж 1.2 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна

Үндсэн хөрөнгийн болон эд хөрөнгийн жилийн эцсийн дотоод тооллогыг газрын даргын баталсан бүрэлдэхүүнээр хийж тайланг удирдлагад танилцуулж, дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаа.

Тооллогоор 465 ширхэг 2,678.6 сая төгрөгийн өртөгтэй, 500,2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 2,178.4 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг тоолон баталгаажуулж ажилтан албан хаагчдын картыг шинэчлэн кодлуулж ажиллалаа. Хагас жилийн тооллогоор 14 ширхэг элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9.4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг актлах, 133 ширхэг 85.5 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн ашиглалтын хугацаа сэргээх хүсэлтийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулж удирдлагад танилцуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн ажиллалаа. ТӨБЗГазраас ирсэн шийдвэрийн дагуу хөрөнгийг актлах болон ашиглалтын хугацаа сэргээх бүртгэлийг хийж гүйцэтгэсэн.

“Санхүүгийн нэгдсэн нэвтрэлтийн систем”-д өөрийн байгууллага дээр үүссэн нэхэмжлэх, И баримт зэргийг татаж авч гүйлгээ хийж байна.

Газрын даргын тушаалаар баталсан Өмч хамгаалах комисс жилд 2 удаа тооллого хийж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын сайтанд тооллогын дүнгээ байршууллаа.

2025 оны 01 дүгээр улиралд ТӨБҮГ-с орсон шалгалтын тайлангаар ирүүлсэн 3 зөвлөмжийн дагуу гарсан зөрчлийг арилгах төлөвлөгөө боловсруулан ажиллаж цаашид алдаа дутагдал гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Газрын даргын тушаалаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх болон хяналт тавих ажилтнуудын ажил үүргийн хуваарийг шинэчлэн мэдээ, мэдээллийг байршуулах, олон нийтэд хүргэх, сайтанд байршуулсан мэдээллийг хянах, ажлын дүн мэдээг гаргах зэргээр шинэчлэн баталсан.

Сар бүрийн мэдээ, улирал, жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, орлого зарлагын гүйлгээ зэргийг www.shilendans.gov.mn сайтад байршуулан нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллаж байна.

Газрын мэдээллийн самбарт сар бүрийн санхүүгийн мэдээг тогтмол шинэчлэн байршуулж хэвшүүлсэн. Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй, хуулийн хугацаанд нийтдээ 32 нэр төрлийн 267 мэдээ мэдээллийг шилэн дансны сайтад байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй байршуулсныг хяналт тавих, дүн шинжилгээ хийх ажлыг Хяналт захиргаа удирдлагын хэлтсээс хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын байгууллагын дүгнэлтийн биелэлт, хэрэгжилт

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд “Уваа-Уул Аудит” ХХК аудит хийсэн. Тус аудитын байгууллагад шаардлагатай тоон мэдээлэл, судалгаа, байгууллагын үйл ажиллагаа, удирдлага хяналтын системийн талаар мэдээллүүдийг хүргүүлэн ажиллаж Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны зардлын төсвийн гүйцэтгэлийн тайланд “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт авсан.



Санхүүгийн тайлангийн аудитаар үйл ажиллагааны зардлын төсвийн гүйцэтгэлд 4 зөвлөмж, Нийгмийн даатгалын сангийн төвсийн гүйцэтгэлд 1 зөвлөмж нийт 5 зөвлөмж авсан. Зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж гүйцэтгэлийг аудитын байгууллагад хүргүүлэн ажиллаа.

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн мөрөөр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Дээд шатны төсвийн захирагчаас ирүүлсэн 9.808.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй 7.765.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тоног төхөөрөмжийг анхны үнээр хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь НДЕГ-ын албан үүргийн түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01-р сарын 15ны өдрийн А/08 дугаар тушаалын дагуу бүртгэсэн болно.
2. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдэлээрээ анхны өртгөө нөхсөн 33 ширхэг 20,432.7 мянган төгрөгийн хөрөнгөнөөс ТӨБЗГ-т актлуулахаар 42 ширхэг хөрөнгийн хүсэлт илгээсэн боловч 13 ширхэг босоо шкаф дахин үнэлгээгээр ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ авч ажилласан.
3. Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийн хууль тогтоомжийн дагуу анхаарч ажиллах болно.
4. Төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулж ажиллалаа.
5. 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан шинээр аж ахуй нэгж бүртгэж хамруулах ажлын төлөвлөгөө гарган батлуулж хуваарийн дагуу ажиллаж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэврийн талаар

2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж буй тэтгэврийн насыг үе шаттайгаар нэмэгдүүлэх хуулийн хүрээнд 2025 онд 60 нас хүрч буй эрэгтэй, 55 нас хүрч буй эмэгтэй даатгуулагч нийт 22 жил түүнээс дээш хугацаанд шимтгэл төлсөн тохиолдолд насандаа, ажилласан жил хүрэхгүй тохиолдолд нас ухарч тэтгэвэр тогтоолгох болзол үйлчилж, хэрэгжилтийг ханган ажиллаа.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ний “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 221 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон Цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 6 хувиар тус тус нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу хуулийн хугацаанд нь нийт 24238 иргэний тэтгэвэрт өөрчлөлтийг хийж журмын дагуу нэмэгдүүлж, тогтоолыг хэрэгжүүлэн ажилласан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу сар бүр ойролцоогоор 26297 иргэнд тэтгэврийг харилцах банк руу цаг хугацаанд нь чирэгдэлгүй түргэн шуурхай шилжүүлэн олгосон. Үүнээс тэтгэврийн төрлөөр нь өндөр насны тэтгэвэр авагч 21472, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч 2248, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1029, зарим иргэдийн тэтгэврийн нэмэгдэл 1279, тэтгэврийн тусгай зохицуулалт 269 иргэнд олгосон байна. Газрын хэмжээнд 2025 онд 1-8 дугаар хороонд шинээр өндөр насны тэтгэвэр 386, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 13, Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 72, Тэтгэврийн тусгай зохицуулалт 47 нийт 279 иргэний материалыг журмын дагуу хүлээн авч sicos-т хүсэлтийг үүсгэн тогтоож хянан баталгаажуулж хугацаанд нь шийдвэрлэсэн. Мөн ЭММЗ-ийн хурлаар орж хөдөлмөрийн чадвар алдалтын акт шинээр тогтоолгосон болон сунгалт хийлгэсэн, цуцлагдсан, тэтгэврийн нэмэгдлийн өөрчлөлт хийлгэсэн иргэдийн тэтгэврийг хуваарийн дагуу



7 хоног бүр заасан хугацаанд тэтгэвэр олголтыг хянан баталгаажуулж харилцах банк руу хуваарийн дагуу олгож ажиллаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэр авагч нь шимтгэл төлж ажилласан хугацааны нэмэгдэл, ажилласан жилээ шалгуулах, 7 жилийн цалингийн дундажаа 5 жилээр сонгох, жишиг цалингаар тэтгэврээ өөрчлөн тогтоолгох 615, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн хөдөлмөрийн чадваргүй гишүүн нь 19 нас хүрсэн тэтгэвэрт өөрчлөлт оруулах 368, хөдөлмөрийн чадвар алдсаны актын сунгалт хийлгэсэн 960 иргэний хүсэлтийг цахим болон цаасан хэлбэрээр өргөдөл гомдлыг хүлээн авч түргэн шуурхай чирэгдэлгүй шийдвэрлэж тэтгэврийг өөрчлөн тогтоож олгосон. Цахим шинэчлэлийг нэвтрүүлж эхэлсэнтэй холбогдуулан 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох иргэд холбогдох тэтгэврийн материалаа цахимаар хүсэлт үүсгэн тогтоолгох боломжийг бүрдүүлж эхэлсэн. Газрын хэмжээнд нэг даатгуулагч цахимаар хүсэлтээ хүргүүлэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврээ тогтоолгон авсан болно.

2025 оны жилийн эцсийн байдлаар 1-24 хороонд өндөр насны тэтгэвэр авагч, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн нийт 196 тэтгэвэр авагч харьяалалын дагуу шилжих хүсэлтийг хүлээн авч SICOS программд хөдөлгөөнийг хийж тэтгэвэр тогтоолтын байцаагч болон хэлтсийн даргаар хянуулан бүртгэл хөтлөн заавар журмын дагуу шилжилт хөдөлгөөнийг хийсэн. Үүнд тэтгэврийн хувийн хэрэг шилжин ирсэн 72, 124 тэтгэвэр авагч иргэний харьяаллын дагуу шилжин явсан байна. Мөн 2025 оны байдлаар тэтгэвэр нь зогсоогдсон, цуцлагдсан, нас барсан тэтгэвэр авагчийн хүсэлтийг тухай бүр хүлээн авч мэдээллийг SICOS программд оруулан хувийн хэргийн хөдөлгөөнийг бүртгэл хөтлөн хариуцсан тэтгэвэр тогтоолтын байцаагчид хүлээлгэн өгч дараа сарын тэтгэврийг журмын дагуу тооцож олгосон.

Тэтгэврийн харилцах банкаа солиулах хүсэлт өгсөн нийт 32 тэтгэвэр авагчийн банкыг журмын дагуу холбогдох материал хүсэлтийг хүлээн авч өөрчлөлт оруулсан.

2025 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт суутгалтай 1-8 хорооны нийт 26 иргэн. Үүнээс жилийн эцсийн байдлаар 5 иргэний суутгалыг зогсоох, шинээр 3 иргэнийг суутгал хийх тогтоолын дагуу суутгал болон зогсоох шийдвэрийг хууль журмын дагуу хийж тогтоолыг скайнердаж мэдээллийг программд оруулан өөрчлөлт хийж сар бүрийн 01—ний өдөр 50 хувийг иргэнд нь үлдсэн 50 хувийг ШШГГ-ын холбогдох дансанд тухайн сарын 10-ны өдрийн дотор шилжүүлсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэмжийн талаар

Тус хэлтэс нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмжийн дагуу тэтгэмжийн хүсэлтийг цахим болон цаасаар хүлээж авч, даатгуулагчийн мэдээллийг мэдээллийн баазадтай тулган шалгаж, тэтгэмжийг үнэн зөв тогтоох, олгох ажлыг түргэн шуурхай гүйцэтгэж ажиллаа.

Тэтгэмж олгохтой холбогдуулан дээд газраас өгсөн чиглэл, зөвлөмжийг баримтлан шимтгэлийн хуримтлагдсан өр авлагатай аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг аж ахуйн нэгж байгууллагаар нөхөн төлүүлж, шимтгэлийн авлага барагдуулах гэрээ байгуулсан аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг нягтлан шалгасны үндсэн дээр гэрээний дагуу шимтгэлээ төлсөн аж ахуйн нэгжийн даатгуулагч нарт журам зааврын дагуу тэтгэмжийг тогтоож, олгож ажилласан. 2024 оноос эхлэн SICOS системийг салбарын хэмжээнд нэвтрүүлж, Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор 2025 онд нийт 15365 даатгуулагчийн Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг цахимаар, Ажилгүйдлийн тэтгэмжийг цахим болон цаасаар хүлээн авч түргэн



шуурхай чирэгдэлгүй хуулийн хугацаанд шийдвэрлэж олгож ажилласан. Мөн мэдээлэл дутуу буюу зөрчилтэй, хуулийн хугацаа нь хэтэрсэн Аж ахуйн нэгж байгууллага болон даатгуулагчийн хүсэлтийг тухай бүр шалгаж буцаасан болно. 2025 оны жилийн эцсийн байдлаар Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 12695 даатгуулагчид 5,7 тэрбум төгрөг, Жирэмсний болон амаржсаны тэтгэмж 2028 даатгуулагчид 10,01 тэрбум төгрөг, Үйлдвэрлэлийн осол, мэргэжилээс шалтгаалах өвчний 135 даатгуулагч, ҮОМШӨ, сэргээн засах сувиллын зардал 4, Ажилгүйдлийн тэтгэмж 1642 даатгуулагчид 8,6 тэрбум төгрөг, Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 726 иргэнд 1,4 тэрбум төгрөгийг үнэн зөв бодож магадлагч эмчээр шалгуулан, хяналтын байцаагч болон хэлтсийн даргаар хянуулан хуваарь, нэхэмжлэлийг үүсгэн олголтыг нягтлан шалгаж жагсаалтыг санхүү бүртгэлийн хэлтэст шилжүүлэн ажилласан. Тайлант жилийн хугацаанд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ дагуу 2 даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон боловч 5 сар дотроо ахин ажлаас чөлөөлөгдөн тэтгэмж авах хүсэлтээ өгч үлдсэн ажилгүйдлийн тэтгэмжийг үргэлжлүүлэн тогтоож харилцах дансанд нь шилжүүлсэн. Мөн НДЕГ-ын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөл, тус газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд 4 даатгуулагч гомдол өгч шийдвэрлүүлсний дагуу 3 даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж, 1 даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн тогтоолын дагуу бодож олгосон.

2025 оны байдлаар Эрүүл мэндийн магадлах зөвлөл нь нийт 36 удаа хуралдаж 1885 иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох, сунгах болон цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих зэрэг асуудлыг магадлан шийдвэрлэсэн. Үүнээс хөдөлмөрийн чадвар алдалт шинээр тогтоолгосон 299, сунгасан 1156, цуцлагдсан 430, Тайлант жилийн хугацаанд Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлыг 7 хоног бүр зохион байгуулах, шийдвэр гаргахад Магадлагч эмч 100% оролцоотой ажиллаж эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар орж сунгалтыг хийлгэж байгаа өрхийн эмч нарт хурлын дэг жаяг, дотоод хяналтын дагуу нэг иргэнийг 7 минутанд багтаан шийдвэрлүүлэх, танилцуулгын хуудсыг стандартын дагуу зөв дэлгэрэнгүй бичих, мэдээллийг бүрэн цуглуулж ирэх, хаягын баталгаажуулалтыг шинээр авч ирэх, эмнэлгийн картны бичилт, эпикриз, оношын баталгаажуулалт, хяналтыг магадлагч эмч өөрийн биеэр шалгаж, буцаан, алдаа зөрчлийг засаж бичүүлэн, дутагдлыг арилган, Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн, 3.6 заалт, 3.7.1 заалт, 5.2.5 дахь заалт, 11.4.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад дотоод хяналтын тавьж байна. 2020-2024 оны тоон тайланг нэгтгэн судалгааг хийж, хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан болж буй зонхилон тохиолдож байгаа тэргүүлэх 5 өвчнийг жагсаалтаар гаргасан. Үүнд:

- ✓ Сэтгэцийн эмгэг
- ✓ Гэмтэл согогийн өвчин
- ✓ Мэдрэлийн өвчин
- ✓ Нүдний өвчин
- ✓ Дотор

Тус газрын дэргэдэх ЭММЗ-ийн хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлүүлж буй иргэдийн тоо өмнөх үетэй харьцуулахад 5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 2025 оны 10 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн “Sicos” программыг нэвтрүүлсэнээр 11 дүгээр сарын 1-ны өдрөөс бүрэн цахимжсантай холбоотой Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон актыг цахимаар баталгаажуулан шийдвэрлэсэн. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын тогтоосон акт цаасан суурьтай хэвлэгдэхгүй тул иргэд, даатгуулагч нар “Төрийн мэдээллийн цахим систем” буюу EMongolia руу орж татаж авах, шинээр тогтоогдсон иргэд банкинд очиж тэтгэврийн нэрийн дансаа үүсгэж байхыг хуралд оролцсон нарийн мэргэжлийн эмч болон өрхийн эмнэлэгийн эмч нарт тухай бүр мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна.

Хяналт шалгалтын талаар



2022-2024 оны тэтгэврийн олголтыг хянан НДЕГ-ын Хяналт шалгалтын газарт дүнг нэгтгэн танилцуулсан. Шалгалтаар нийт 15720,9 сая төгрөгийн илүү олголт 39948,5 сая төгрөгийн дутуу олголтын зөрчил илэрсэн.

2025 оны 09 дүгээр сарын 25-нд тус газрын Хүний нөөцийн мэргэжилтэн Т.Сайханжаргалын боловсруулан удирдлагад танилцуулан батлуулсан зөрчилтэй 8 тушаалыг шалган, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар судлан дүгнэлт гаргуулахаар Ёс зүйн дэд хороонд шилжүүлэн өгсөн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 01/2065 дугаартай албан бичгийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан нийт 453 ажил олгогчийн 2295 даатгуулагчтай холбоотой зөрчилтэй байх магадлалтай жагсаалтыг үндэслэн хяналт шалгалтын ажлыг хийж, хуулийн хугацаанд шалгалтын дүн мэдээг 09 дүгээр сарын 20-ны өдөр НДЕГ-ын Хяналт шалгалтын газар хүргүүлэн ажилласан. Дотоодын төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар нэр бүхий 453 ажил олгогчийн тайлангийн үндэслэлийг тулган шалгахад тайланд хүн нэмж тайлагнасан, даатгуулагчийн төрлийн код буруу тайлагнасан зэрэг зөрчилд залруулга хийгдсэн байх бөгөөд Улсын байцаагчийн акт, Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцон эрх бүхий албан тушаалтнуудаар хянуулан, баталгаажуулсан тул шалгалтаар зөрчил илрээгүй.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2025 оны 11 дугаар сарын 05-ны өдрийн 09 дугаартай удирдамжийн дагуу Хяналт, шалгалтын газрын ахлах мэргэжилтэн, улсын байцаагч А.Сожидмаа, мэргэжилтэн, улсын байцаагч Г.Бямбажаргал нар 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн ажлын 10 хоногийн хугацаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Тус шалгалтын хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны Зөрчлийн тухай хуулиар болон Улсын байцаагчийн актуудыг шалгасан.

Газрын даргын 2025 оны 1-р сарын 13-ны өдрийн баталсан 02 тоот удирдамжийн дагуу ажил олгогчдод Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах, хуримтлагдсан өр авлагыг бууруулах, хамрах хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр ажил олгогчийн жагсаалт гарган батлуулж хуваарийн дагуу байцаагчид хяналт шалгалт хийсэн. Тайлант хугацаанд нийт 202 ажил олгогчийг шалгаж, 1,2 тэрбум төгрөгийн цалингийн санд 279,6 сая төгрөгийн акт тогтоож 139,8 сая төгрөгийн алданги тогтоож 100% төлүүлэн нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна

Зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн заалтуудыг үндэслэн 38 аж ахуйн нэгж байгууллагад 22,250,00.00 төгрөгийн торгууль оногдуулан төлүүлж, Чингэлтэй дүүргийн прокурорын газарт хянуулан хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн.

Газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 03 тоот удирдамжийн дагуу Эрчист Монгол ХХК-ны 2025 оны санхүүгийн баримтад тулгуурлан хяналт шалгалт хийсэн.

Газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 04 тоот удирдамжийн дагуу “Монголын төмөр зам” ТӨХК-д Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан тогтоол, шийдвэр, журам, зааврын биелэлтийг шалгах, шимтгэлийн өр, авлагын тооцоо түүний барагдуулалтын байдлыг шалгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор хяналт шалгалт хийсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/206 “Финанс мониторинг” нэгдсэн арга хэмжээний шалгалтын нэгдсэн удирдамжийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 08/2436 дугаартай албан бичгээр шалгах



байгууллагын нэрс, ажлын хуваарийг ирүүлсний дагуу банк бус санхүүгийн байгууллагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нэр бүхий 10 байгууллагын 2020-2024 онуудын санхүүгийн баримтад Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг Хан-Уул дүүргийн Хяналт шалгалтын улсын байцаагч нартаа хамтран тус шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтад хамрагдсан 10 банк бус санхүүгийн байгууллагыг шалгахад:

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага тооцож, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн торгуулийг 100 хувь, шимтгэл, алдангийг 100 хувиар барагдуулсан байна.

2025 оны 4 дүгээр улиралд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн 5592 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/199 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээн авч, хянан баталгаажуулан, байгууллага тус бүрээр хавтас нээж зохих журмын дагуу ажиллаж байна.

НДЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2022-2024 онуудын шинээр тогтоолгосон тэтгэвэр, Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тогтоолгосон, нас барсан, зогсоосон хувийн хэрэг, тэтгэврийн олголтыг программтай тулган шалгасан. Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг Газрын даргын тушаалаар хяналтын байцаагч болон тэтгэврийн байцаагч нарт хуваарилан өгч актын биелэлтэд хяналт тавьж ажилласан.

Газрын хэмжээнд актын биелэлт 130108096 төгрөгийн төлбөр зөрчлийн актаас 82209304 төгрөгийг барагдуулан 63 хувиар бууруулж ажилласан.

НДСОТТХуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг зөрчиж нас барсны дараа сарын тэтгэврийг дутуу тооцож олгосон 18 тэтгэвэр ававгчийн 15.515.574 төгрөгийн тэтгэврийг тулган шалгаж холбогдох мэдээллийг тулган харилцах дансанд шилжүүлэн нөхөн олгосон.

5 даатгуулагчид илүү олгосон 16971060 төгрөгийн төлбөр зөрчлийн актнаас 4 даатгуулагчийн 3758657 төгрөг, 7 даатгуулагчид нөхөн олгох 12208703 төгрөгнөөс 2 тэтгэвэр авагчийн 2806880 төгрөгийг нөхөн олгосон.

НДЕГ-ын Нийгмийн хамгааллын Улсын байцаагчийн актнаас илүү олгосон 63 даатгуулагчид 71.100.033,40 төгрөгийн акт тавигдсанаас 5 даатгуулагчийн 3442737,97 төгрөгийг барагдуулан 4,8 хувиар бууруулж ажилласан.

Нэг цэгийн үйлчилгээний талаар

НДЕГ-ын даргын 2025 оны шинэчлэгдсэн бүтэц орон тооны дагуу тус хэлтэст нэг цэгийн үйлчилгээний нийт 4 байцаагч, мэргэжилтэн ажиллаж иргэд даатгуулагч нарт түргэн шуурхай, хүртээмжтэй, чирэгдэлгүй нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэн ажлаж байна.

Үйлчилгээ авах гэж ирж буй Аж ахуйн нэгж байгууллага болон иргэд даатгуулагч нар хүлээлгийн танхимд хүлээж коиск машинаас үйлчилгээ авах дугаар авч байцаагч мэргэжилтнүүдээс хүссэн мэдээлэл, зөвлөгөөгөө нэг дороос хүртээмжтэй түргэн шуурхай авч байна. Нэг цэгийн байцаагч нар өргөдөл гомдол, тэтгэврийн нэмэгдэл, шинээр тэтгэвэр, тэтгэмж авах иргэд, даатгуулагчдад зөвлөгөө өгөх, тэдэнд баримт бичгээ эрх зүйн үндэслэлтэй зөв бүрдүүлэхэд нь туслах, зөрчилтэй баримтын зөрчлийг арилгуулах, дутуу баримтыг гүйцээж бүрдүүлэх, холбогдох лавлагааг архиваас хэрхэн гаргуулах, Шүүхээр ажилласан жилээ тогтоолгох зэрэгт зөвлөгөө мэдээлэл өгч чиглүүлэн хууль журмын дагуу холбогдох материалыг бүрдүүлэн авч скайнертаж scos программд хүсэлт үүсгэн мэдээллийг үнэн зөв оруулан тогтоолтын байцаагчид тухай бүр хүлээлгэн өгч ажилласан.

Хамралт, Орлогын талаар



Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, иргэнийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлүүлэх, авлага барагдуулах шат дараалсан ажлуудыг зохион байгуулан ажиллалаж 4 улирлын байдлаар нийгмийн даатгалын санд **759,198.98** сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс **760 610.31** сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг **100** хувиар биелүүлсэн.

Д/Д	Огноо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь
1	2025 оны 01-р сар	44,872.05	43 359.24	96%
2	2025 оны 02-р сар	45,490.64	55 351.38	121%
3	2025 оны 03-р сар	58,306.94	61 573.31	105%
4	2025 оны 04-р сар	57,912.4	57 032.55	98%
5	2025 оны 05-р сар	62,731.09	55 071.64	88%
6	2025 оны 06-р сар	67,821.70	53 034.94	78%
7	2025 оны 07-р сар	57,421.31	69 151.77	120%
8	2025 оны 08-р сар	64,046.54	59 687.4	93%
9	2025 оны 09-р сар	68,014.82	55 023.74	81%
10	2025 оны 10-р сар	67,916.45	57 075.01	84%
11	2025 оны 11-р сар	71,563.66	54 059.77	75%
12	2025 оны 12-р сар	93,101.33	140 189.56	102%
Нийт дүн		759 198.98	760 610.31	100%

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалын санд **760 610.31** сая төгрөгийн орлого төвлөрүүлж, **62,228.07** сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай гарсан бөгөөд орлогод эзлэх авлагын хэмжээ **12** хувь байна.

Хамралт:

2025 оны 04 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй **21,748.99** сая төгрөгийн цалингийн сан бүхий **590** аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын программд шинээр бүртгэж, мэдээллийг бүрэн оруулж, орлогын байцаагчид хуваарилан ажиллалаа. Албан журмын даатгалд **4315** даатгуулагчийг шинээр хамруулсан.

Тайлан авах ажлын хүрээнд:

2025 оны 4 дүгээр улиралд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн **5592** ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/190 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээн авч, хянан баталгаажуулан, байгууллага тус бүрээр хавтас нээж зохих журмын дагуу ажиллаж байна.



Вэб программаар илгээсэн зөв тайлан хүлээн авах, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулах болон холбогдох мэдээ мэдээлэл мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна.

2025 оны 4 дүгээр улиралд ажил олгогчоос цалин залруулга, нөхөн тайлан, ажил олгогчийн үйл ажиллагаатай холбоотойгоор нийт **250** албан хүсэлт, даатгуулагч иргэдээс регистр нэгтгэх, даатгуулагчийн үндсэн мэдээлэл засуулахаар нийт **80** хүлээн авч, холбогдох анхан шатны баримтыг үндэслэн хүлээн авч системийн шинэчлэл дууссаны дараа шийдвэрлэхээр хүлээгдэж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бүүруулах талаар

2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр батлагдсан шимтгэлийн авлага барагдуулах, орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр 2025 онд хийж гүйцэтгэх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан өр авлага барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

2025 оны 09 дүгээр сарын 10-ний өдөр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд таниулах, мэдээллээр хангах зорилгоор Нийгмийн даатгалын багц хуулийн сургалтыг зохион байгуулж байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд “ЯПОН УЛСАД ТӨВТЭЙ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН”-гийн байгууллагын ажилтан, албан хаагчдад “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн талаар Тэтгэврийн хяналтын байцаагч Г.Цэрэннадмид, Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч Б.Энхмишээл нар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудыг танилцуулан, ажилтнуудын тавьсан нийгмийн даатгалын талаарх асуултад хариулт өгч ажиллав.



2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын сургалтын танхимд 1-24 дүгээр хорооны Засаг дарга болон Ахмадын хорооны дарга нарт “Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулж ажиллаа.

Тус сургалтыг Чингэлтэй дүүргийн Хайлааст дахь Нийгмийн даатгалын хэлтсийн дарга З.Мөнхнаран мэдээ мэдээлэл, зөвлөмж өгч ажиллалаа.



2025 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын сургалтын танхимд 1-24 дүгээр Хорооны зохион байгуулагч нар болон Нийгмийн ажилтан нарт “Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулж ажиллаа. Тус сургалтыг Чингэлтэй дүүргийн Хайлааст дахь нийгмийн даатгалын хэлтсийн дарга З.Мөнхнаран мэдээ мэдээлэл, зөвлөмж өгч ажиллалаа.



2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн талаар Тэтгэврийн тогтоолт, олголтын байцаагч Б.Нямтуяа, Тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч Ц.Эрдэнэжаргал нар Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний хэлтэс албан хаагчдад Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудыг танилцуулан, ажилтнуудын тавьсан нийгмийн даатгалын талаарх асуултад хариулт өгч ажиллав.



2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд таниулах, мэдээллээр хангах зорилгоор Нийгмийн даатгалын багц хуулийн сургалтыг зохион байгуулж байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд “Чингэлтэй дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн” ажилтан, албан хаагчдад “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн талаар Тэтгэврийн хяналтын байцаагч А.Энхжаргал, Тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч Н.Одгэрэл нар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудыг танилцуулан, ажилтнуудын тавьсан нийгмийн даатгалын талаарх асуултад хариулт өгч ажиллав.



2025 оны 09 дүгээр сарын 29–ний өдөр "ИТГЭЛЦЛИЙН АЯН"-ны хүрээнд Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар тайлагнадаг байгууллагын захирал, эдийн засагч, нягтлан, хүний нөөцийн менежерүүдэд Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваадорж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын дарга С.Лхагвадорж нар ажил олгогчдын зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа.


Ажил олгогчдын зөвлөгөөнд Нийгмийн даатгалын багц хууль, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд, журам заавар, цахим үйлчилгээний талаар аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчдод сурталчлан таниулах, шимтгэл төлөлтийн тайланг үнэн зөв хугацаанд нь гаргах талаар мэдээлэл өгөх мөн Нийгмийн даатгалын ерөнхий газраас шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой үйл ажиллагааг дэмжих, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгоход хамтран ажиллах зорилго бүхий “Итгэлцлийн аян”-ыг түгээхэд оршиж байна.



Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч шилдэг 10 ажил олгогч шалгаруулж мөн 5 аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодогч нарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын жуух бичгээр шагналаа. Нягтлан бодогч нарт Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд, журам заавар, цахим үйлчилгээний талаар, шимтгэл төлөлтийн тайланд гарч байгаа зөрчлүүдийг арилгах, хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнахад мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга замыг хэлэлцэж, цаашид зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх талаар сургалт уулзалтыг зохион байгуулж харилцан санал солилцлоо.

2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд таниулах, мэдээллээр хангах зорилгоор Нийгмийн даатгалын багц хуулийн сургалт цахимаар зохион байгуулагдлаа.

Энэхүү арга хэмжээний хүрээнд “Оюу толгой” ХХК-ийн уул уурхайн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны ажилтан, албан хаагчдад “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн талаар Хайлааст дахь нийгмийн даатгалын хэлтсийн дарга З.Мөнхнаран, Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч Г.Ганцэцэг нар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудыг танилцуулан, ажилтнуудын тавьсан нийгмийн даатгалын талаарх асуултад хариулт өгч ажиллав.



2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд таниулах, мэдээллээр хангах зорилгоор Нийгмийн даатгалын багц хуулийн сургалтыг зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээний хүрээнд “Ньютел ХХК” ажилтан, албан хаагчдад “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн талаар Хайлааст дахь нийгмийн даатгалын хэлтсийн дарга З.Мөнхнаран, Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч Б.Энхмишээл нар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудыг танилцуулан, ажилтнуудын тавьсан нийгмийн даатгалын талаарх асуултад хариулт өгч ажиллав.



“ЗӨВЛӨӨ, ТУСАЛЪЯ” АЯН

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газраас “Зөвлөө, Тусалъя” явуулын үйлчилгээ 2025 оны 10 сарын 07-ний өдөр 10:00-16:00 цагт Чингэлтэй дүүргийн 3, 5, 8, 9, 12, 15, 18, 19, 21-р хороонуудын иргэний танхимд боллоо.

Нийгмийн даатгалын багц шинэчилсэн хуулийн талаар тус дүүргийн 1-24 хорооны иргэд даатгуулагчдыг хамруулж, 2026-2027 онд 1966, 1967 оны эрэгтэй, 1971, 1972 оны эмэгтэй өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсэж буй нийт 377 гаруй иргэдийн материалыг урьдчилан шалгаж, зөвлөгөө өгөх, нийгмийн даатгалын гар утасны аппликейшныг сурталчлах, баталгаажуулалтыг хийх, сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх талаарх сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.

Мөн 2025 оны 10 дугаар сарын 13 өдөр Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн Монголын мэдээ сувгийн өдрийн мэдээллийн хөтөлбөрөөр Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын алба үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваадорж зочноор оролцож “Зөвлөө, Тусалъя” явуулын үйлчилгээ болон тэтгэвэр, тэтгэмж, цаг үеийн асуудлаар мэдээ мэдээлэл өгч ажиллалаа.



2025 оны 10 дугаар сарын 22-ний өдөр Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн хүсэлт тавьсны дагуу тус газрын удирдлага, ажилтнуудад “Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал” сэдвээр мэдээлэл өглөө.

Сургалтад Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газрын Тэтгэврийн хяналтын байцаагч Г.Цэрэннадмид, Тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч Ц.Эрдэнэжаргал нар Нийгмийн даатгалын тухай хуулийн хувь хэмжээ, тэтгэвэр, тэтгэмж болон ажил олгогчид олгож буй хуулийн бусад боломж, заалт сэдвээр сургалт орж, албан хаагчдад сонирхсон асуултад



мэдээлэл

өгч

ажиллалаа.



АВЛИГА, АШИГ СОНИРХЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ

2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээг жил бүр хөндлөнгийн байгууллагаар хийлгэж олон нийтэд мэдээлдэг бөгөөд Нийгмийн даатгалын салбар 2024 оны шударга байдлын үнэлгээгээр 5 дугаар байрт эрэмбэлэгдсэн.

Сургалтаар авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанаас ангид ажиллахад анхаарах асуудал, түгээмэл алдаа дутагдлын талаар АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулуун зөвлөмж мэдээлэл өглөө. Авлигатай тэмцэх газраас хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчил гаргахгүй, ёс зүйтэй, хариуцлагатай, хууль дүрмийн хүрээнд ажиллахыг Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчдад сургалтын үеэр санууллаа.

2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Чингэлтэй дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулж буй “Авлига ашиг, сонирхлоос ангид байх нь” сэдэвт сургалт Нийслэлийн онцгой байдлын газрын хурлын танхимд зохион байгуулагдлаа. Сургалтад Хяналт шалгалтын улсын байцаагч Д.Бат-Эрдэнэ, Тэтгэмжийн хяналтын байцаагч, мэргэжилтэн Ц.Жаргалсайхан, Нэг цэгийн үйлчилгээний байцаагч, мэргэжилтэн Э.Урангоо, Цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Б.Анхтуяа, Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Б.Баатархүү, Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн Э.Хулан нар оролцсон юм.



2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр “Төрийн болон албаны нууцын тухай хууль”-ийн талаар Үндэсний тагнуулын их сургуулийн ахлах багш Ph доктор, дэд хурандаа Ш.Насанбат сургалт зохион байгууллаа. Төрийн болон албаны нууцын тухай хууль” 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан.

“Төрийн нууц” гэдэг нь задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээлэл гэж хуульд заасан. “Албаны нууц” гэдэг нь задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх зэрэг мэдээ мэдээлэл өгч ажиллав.



“БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ БА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР” СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газар нь “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагатай хамтран албан хаагчдын байгууллагын болон үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилгоор “Байгууллагын соёл ба үйлчилгээний чанар” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Сургалтын зорилго нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын зэрэгцээ байгууллагын дотоод уур амьсгал, хамт олны харилцааны соёлыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн юм.

Сургалтын үеэр “Байгууллагын соёл ба иргэдэд үзүүлэх үйлчилгээний хандлага”, “Харилцааны соёл ба итгэлцлийн орчин”, “Ажилтан бүрийн үүрэг, хариуцлага” зэрэг сэдвээр “Хөгжлийн шийдэл” ТББ-ын бизнесийн зөвлөх ментор Н.Баярчимэг онол, туршлагыг хослуулсан хэлбэрээр мэдээлэл хүргэлээ.

Сургалтын үр дүнд албан хаагчид байгууллагын үнэт зүйл, хамт олны уур амьсгал, үйлчилгээний чанар хоорондоо шууд уялдаатай болохыг ойлгож, иргэдэд найрсаг, хүртээмжтэй, хариуцлагатай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр шинэ санаачилга, хандлагыг төлөвшүүллээ.

1. Соёл түгээе постер-1 линк-
<https://www.facebook.com/photo?fbid=1235139211983646&set=a.250871313743779>
2. Соёл түгээе постер-2 линк-
<https://www.facebook.com/photo?fbid=1238799074950993&set=a.250871313743779>
3. Соёл түгээе Видео линк- <https://www.facebook.com/reel/1344918833922773>
4. Соёл түгээе сургалт линк- <https://www.facebook.com/chingeltei.nd/posts/1237750801722487>
5. Соёл түгээе Видео линк- <https://www.facebook.com/reel/25005371572487398>




2025 оны 11 дүгээр сарын 25-ний өдөр Дэнжийн 1000 зах болон “Нарантуул 2” худалдааны төвд худалдаа, үйлчилгээний жижиг дунд бизнес эрхлэн ажиллаж буй иргэдэд даатгуулагч нарт Нийгмийн даатгалын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн талаар олон нийтэд таниулах, мэдээллээр хангах зорилгоор зөвлөгөө өгч ажиллалаа.

Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газрын Нэг цэгийн үйлчилгээний байцаагч Ц.Болормаа, Нэг цэгийн үйлчилгээний байцаагч Л.Мөнхгэрэл, Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Б.Баатархүү нар Нийгмийн даатгалын тухай хууль, хэрхэн Нийгмийн даатгал төлөгч болох, ажил олгогчийн эрх, үүрэг, НДШ-ийн хувь хэмжээ, тэтгэвэр, тэтгэмж болон ажил олгогчид олгож буй бусад төлбөр сэдвээр иргэн, хуулийн этгээд, бизнес эрхлэгчдийн сонирхсон асуултад хариулт өглөө.



Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран сургалт зохион байгууллаа

2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Чингэлтэй дүүргийн 1-24 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга “нар” “Эрүүл мэндийн магадлалтай холбоотой эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтийн” талаар Нийгмийн даатгалын газрын Магадлагч эмч Д.Дэлгэрцэцэг Нийгмийн даатгалын багц хууль, эрүүл мэндийн магадлалтай холбоотой эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтийн талаар Чингэлтэй дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх мэдрэл, сэтгэц, дотор, гэмтэл, сонсгол, нүд зэрэг 5 өвчнийг бууруулах, хувь хугацаа тогтоолгосон, сунгуулсан, цуцалсан, хөдөлмөрийн нөхцөл өөрчилсөн даатгуулагч иргэний тэтгэмж, даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журмын асуудлаар болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж асуулт хариулт өгч ажиллав.



2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Даатгуулагч иргэдийн эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгц, шинжилгээ, оношилгооны дүгнэлт бүрдүүлэлт, цахим мэдээллийн сангийн хяналтыг сайжруулах сарын аян эхлүүлээ. ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт, даатгуулагчийн эрүүл мэндтэй холбоотой амбулаторийн картын хавтаслалт, эмх цэгц, шинжилгээ оношилгооны дүгнэлт, хяналт, баталгаажилтыг сайжруулахаар Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөс Чингэлтэй дүүргийн 1-24 хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийн дунд 2 сарын аяныг зохион байгуулж, даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх, эрүүл мэндийн магадлалтай холбоотой тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, магадлалын харилцаанд оролцогч талуудыг болзошгүй алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүнг нэмэгдүүлэхээр ажилл



2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Чингэлтэй дүүргийн Нийгмийн Даатгалын Газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь Сүхбаатар аймгийн Нийгмийн Даатгалын Газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлтэй “Ижил мэргэжилтний үзлэг”ийг зохион байгууллаа. Ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулснаар Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цахим мэдээллийн сангийн бүртгэлд тулгуурлан эрүүл мэндийн магадлалтай холбоотой тушаал шийдвэрийн хэрэгжилтэд цахим хяналт хийж, магадлалын үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага, түүнд тавих дотоод хяналт сайжирч, бусдын сайн туршлагаас суралцах боломж бүрдэнэ.



“ТЭГШ ЭРХ, ТЭГШ БОЛОМЖ” УРИАН ДОР ЧУУЛГА УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1981 оноос жил бүрийн 12 дугаар сарын 03-ны өдрийг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр” болгон тэмдэглэж эхэлсэн. Энэ өдрийг угтан Чингэлтэй дүүрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдугаар чуулга, уулзалтыг 2025 оны 11 дүгээр сарын 05 өдөр Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас зохион байгуулж Нийгмийн даатгалын газар хамтран оролцож байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд зориулсан эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, цаашдын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нь энэхүү чуулга уулзалтын зорилго бөгөөд “Тэгш эрх, тэгш боломж” уриан дор зохион байгуулж байна.

Чингэлтэй дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 3843 иргэн бий, үүнээс 536 нь хүүхэд, 3307 нь хөдөлмөрийн насныхан, хүйсийн харилцааг авч үзвэл эрэгтэй 2178, эмэгтэй 1439 Харин хөдөлмөрийн насны иргэдээс 249 нь хөдөлмөр эрхэлж, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын судалгааны үр дүнгээс харахад тус хөдөлмөрийн чадвар алдалтын шинэ тогтоолт жил ирэх тусам буурч, өмнөх оноос 27,8%-иар буурсан байна. Эрүүл мэндийн Магадлалын зөвлөл нийт 3617 хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа шалтгааныг тогтоосон иргэн сунгуулсан байхаас 2490 иргэн Нийгмийн даатгалын сангаас , 1127 иргэн Халамжаас тэтгэвэр авдаг гэсэн мэдээлэл байна.

Мөн ТҮ24 сувгийн өдрийн мэдээллийн хөтөлбөр болон бусад мэдээллийн сайтуудаар “Тэгш эрх, тэгш боломж” уриан дор зохион байгуулж арга хэмжээний талаар Нийгмийн даатгалын багц хууль, эрүүл мэндийн магадлалтай холбоотой эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтийн талаар Чингэлтэй дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх мэдрэл, сэтгэц, дотор, гэмтэл, сонсгол, нүд зэрэг 5 өвчнийг бууруулах, хувь хугацаа тогтоолгосон, сунгуулсан, цуцалсан, хөдөлмөрийн нөхцөл өөрчилсөн даатгуулагч иргэний тэтгэмж, даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журмын асуудлаар мэдээ мэдээлэл өгч ажиллалаа.

<https://www.facebook.com/100064627364545/videos/pcb.1246645970832970/1720892521920371>



- 2025.02.20-ны өдрөөс эхлэн Албан хаагчдын монгол бичгийн ур чадварыг дээшлүүлэх үүднээс Нийслэлийн 50 дугаар дунд сургуулийн монгол хэл, бичгийн багш Ц.Энхболортой хамтран мэргэжлийн түвшинд, чанартай, ойлгомжтой арга зүйгээр хичээлийг явуулж, үр дүнтэй сургалтыг зохион байгууллаа.



2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй “E-Police” аппликейшн ашиглах болон зөрчил илрүүлэх заавар, зөвлөмж, сургалтад албан хаагчдыг хамрууллаа. Мэдээллийн технологийн ажилтан Э.Нэргүй, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Б.Баатархүү, Сангийн нягтлан бодогч Ө.Чимэд-Рэгзэн, Нэг цэгийн үйлчилгээний байцаагч Л.Мөнхгэрэл, Хамралт, орлого, өр хариуцсан байцаагч С.Ганцэцэг нар тус сургалтад хамрагдав.



2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил арга хэмжээ Чингэлтэй дүүргийн Бие тамирын спорт ордонд болж, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчид идэвхтэй хамрагдаж оролцлоо. Т.Сайханжаргал Ц.Алтанцэцэг Д.Өнөржаргал Б.Баатархүү Б.Даваасүрэн Б.Анхтуяа Б.Энхмишээл Б.Номинзул Ц.Эрдэнэжаргал нарын 9 албан хаагч хамрагдлаа.



2025 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд Нийгмийн даатгалын байгууллага 2025 ондоо багтаан 330 суманд нийгмийн даатгалын цахим системийг нэвтрүүлж, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагч, харилцагчдад түргэн шуурхай, ил тод, нээлттэй үзүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд албан хаагчдыг нийгмийн даатгалын мэдээллийн “Sicos” системийн талаар нэгдсэн ойлголттой болгох, дадлага хийх, системийн дата мэдээллийг ашиглах, процессын шинжтэй ажлуудыг хөнгөвчлөх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 21 аймаг, 9 дүүргийн албан хаагчдыг чадавхжуулах хоёр өдрийн сургалтад хамрагдлаа.




НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИД АВЛАГА БУУРУУЛАХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЛӨӨ

Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүйн улмаас даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээ авч чадахгүй, хохирч үлддэг. Тиймээс нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, тэдэнд нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэхэд анхаарч 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарласан.

2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зорилтот жилийн хүрээнд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооноос системийн хэмжээнд үүсээд байгаа

авлагыг барагдуулах авлагын менежментийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 9 дүүргийн албан хаагчид танхимаар, 21 аймгийн албан хаагчид цахимаар хамрагдлаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээг бууруулснаар даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох, санхүүгийн эрсдэлээс хамгаалах, нийгмийн баталгааг хангах нөхцөл бүрдэх юм.

“Нийгмийн даатгалын байгууллагын авлагын менежмент, авлагыг барагдуулах арга зам” сэдэвт сургалтад Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын алба хаагчид болох Б.Энхмишээл Б.Номинзул Ц.Алтанцэцэг Б.Баатархүү А.Ариунтуяа нар сургалтад хамрагдлаа.



2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Чингэлтэй дүүргийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиуд, дүүргийн 100 гаруй аж ахуйн нэгж байгууллагууд гамшгаас бэлэн байдлын үзлэгт хамрагдаж байна. Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ажлын хэсэг гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулан ажиллаж байна.

Тус Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого болон бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, болзошгүй гамшгийн үед гамшгаас хамгаалах томилгоот бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлыг сайжруулах, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой юм.



2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ажлын хэсэг гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулан ажиллаж байна.

Тус гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого болон бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, болзошгүй

гамшгийн үед гамшгаас хамгаалах томилгоот бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлыг сайжруулах, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой юм.



2025 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Төрийн байгууллагын төгөлдөршлийн тогтолцоо, гүйцэтгэлийн үнэлгээ азийн загвар байгууллагын төслийн эхний уулзалт амжилттай болж өндөрлөлөө. Азийн бүтээмжийн байгууллагын зөвлөх ноён Гая Гордон, Монголын Бүтээмжийн Төв, Засгийн Газрын Хяналт Хэрэгжүүлэх газар болон Чингэлтэй дүүргийн Нийгмийн Даатгалын газрын төлөөлөлтэй уулзаж, төслийн зорилго, хэрэгжилтийн талаар ярилцлаа.

Төсөл нь төрийн үйлчилгээний үр ашиг, чанарыг сайжруулахад чиглэсэн олон улсын аргачлалыг Монголд хэрэгжүүлэх онцлогтой юм.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТИЙН ХЭРЭГСЭЛ, ЦАХИМ СҮЛЖЭЭГЭЭР ХИЙЖ, ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

2025 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг Монголын үндэсний олон нийтийн радио телевиз хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Монголын радио, Гандан телевиз, нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр мэдээ, мэдээлэл бэлтгэж, ажил олгогч, цаг үеийн асуудлаар мэдээлэл хүргэж ажилласан. ГБХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.






Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах талаар иргэд даатгуулагч, ажил олгогч нарт нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг цахимаар түргэн шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор постер -20 орчим, рийл 20 гаруйг хийж газрын албан ёсны Facebook цахим хаягаар дамжуулан иргэд даатгуулагчдад тогтмол мэдээ мэдээлэл хүргэж, батлагдсан хуваарийн дагуу сард 2 удаа шууд Live хийж, цахимаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.



Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хүсэлтийг цахимаар хүлээж авах, тогтоох, олгох ажлыг сурталчлан таниулах зорилгоор тус газар нь тэтгэмжийн хүсэлтийг цахимаар илгээх QR код бүхий 2 төрлийн заавар хийж, гарын авлага брошюр бэлтгэн, иргэд даатгуулагчид, ажил олгогч нягтлан бодогч нарт тараан сурталчилж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор 2025 оны 7,8,9 дүгээр сард тус газраар үйлчлүүлсэн иргэдээс түүврийн аргаар нийт **440** иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн ажиллаа. Үйлчилгээний газрын ажил үйлчилгээг авч буй үйлчлүүлэгч болон нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшин тодорхойлох үйлчлүүлэгчдийн хандлагыг тандан судлах, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг жилд хэд хэдэн удаа авч байна. Иргэд даатгуулагчдыг сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын нэг цэгийн үйлчилгээний байцаагч нарын товч мэдээлэл бүхий QR, сэтгэл ханамжийн судалгааны QR кодыг байцаагч тус бүрийн өмнө байршуулан иргэд даатгуулагчдад сурталчлан, мэдээлэл өгч ажиллаж байна. Мөн сэтгэл ханамжийн судалгааг газрын албан ёсны веб хуудсаар шууд дамжуулан авч судалгааны нэгтгэл дээр анализ хийж ажиллаж байна.



Архив мэдээлэл лавлагааны талаар

1992-1994 оны байгууллагын шимтгэл төлөлтийн тухай лавлагаа 330, 1995-2006 оны хувь хүний шимтгэл төлөлтийн лавлагаа 1303, 1990-2000 нөхөн даатгалын тодорхойлолт 430, тус тус архивын баримтаас шүүн иргэд, даатгуулагчдад олгосон.

Абле программаар бусад аймаг, дүүргүүдээс ирсэн хүсэлтүүдийн дагуу нийт 467 иргэний шимтгэл төлөлтийн лавлагааг гарган хүргүүлж, архивын лавлагаа авах хүсэлтийг бусад аймаг, дүүргүүдэд 367-г илгээж, 467 хүсэлтийн хариуг иргэд, даатгуулагчдад хүлээлгэн өгч ажилласан байна.

Эдок программаар Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсээс ирсэн 54 албан бичгийн хариуг боловсруулж хуулийн хугацаанд нь хүргэж ажилласан.

Мөн газрын дотоод үйл ажиллагаанд шаардагдсан 315 баримтыг дотоод хэрэгцээнд түр ашиглуулан, бүрэн хүлээн авч тухай бүр тэмдэглэл хөтөлж ажилласан.

2024 оны Байнга хадгалах хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж, Түр хадгалах хадгаламжийн нэгж бүхий **нийт 792 гаруй** баримтуудыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалттай тулган бүртгэлжүүлж, дугаар өгч, нягтруулсан шүүгээнд байршуулсан. Газрын архивт 9 төрлийн бүртгэл бүхий баримт хадгалагдаж байна.

Архивт сан хөмрөгт хадгалагдаж байгаа 1994-2024 оны баримтуудыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу нэг бүрчлэн дугаарлаж, нягтруулсан шүүгээнд хайрцаглан байршуулсан.

“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх”

Тайлант хугацаанд тус хэлтсийн байцаагч, ажилтнуудыг дараах сургалтуудад хамруулав. Үүнд:

- Төрийн албан хэргийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хос бичгээр хөтлөх болсон тухай зөвлөмжийн дагуу Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн 3/346 тоот албан бичгийн дагуу 2 дугаар сарын 20-ны өдрөөс Пүрэв гариг болгон зохион байгуулсан Монгол бичгийн сургалтад хамруулсан.
- 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр “НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТОГТОЛЦООГ ЗӨВ СИСТЕМТЭЙ БОЛГОНО” сэдвээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Залуу судлаачдыг дэмжих сан ТББ-тай хамтран

нийгмийн хамгааллын бодлогуудаа системийн шинжилгээг хэрхэн хийх тухай сургалт;

- 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Төрийн албаны зөвлөл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн албаны хамтран зохион байгуулсан Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийн шинэ модуль, дэд системүүдийг танилцуулах, хэрэглээнд нэвтрүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт;
- Монголын Бүтээмжийн төвөөс зохион байгуулсан 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдөр “Төрийн байгууллагын төгөлдөржилтийн тогтолцоо гүйцэтгэлийн үнэлгээ” танхимын сургалт;
- Бүтээмжийн төвөөс зохион байгуулсан 2025 оны 3 дугаар сарын 19-ны өдөр Төрийн байгууллагын төгөлдөржилтийн тогтолцоо гүйцэтгэлийн үнэлгээ сургалт;
- 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 16-ны өдрийн хооронд “Багшлах ур чадвар Багшийн ёс зүй харилцаа” сургалт;
- 2025 оны 04 дүгээр сарын 28, 29-ны өдөр Нийгмийн даатгалын мэдээллийн “Sicos” системийн талаар нэгдсэн ойлголттой болгох, дадлага хийх, системийн дата мэдээллийг ашиглах, процессын шинжтэй ажлуудыг хөнгөвчлөх зорилгоор НДЕГ болон 21 аймаг, 9 дүүргийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт;
- 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын ерөнхий прокурорын газраас “Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-г улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжрах, харилцан мэдээлэл солилцох сургалт;
- 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Нийслэлийн засаг даргын 2025 оны Гамшгаас хамгаалах “Команд штаб”-ын сургууль, бэлдэх байдлын үзлэг зохион байгуулах тухай А/66 дугаар захирамж, дүүргийн засаг даргын 2025 оны “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах тухай” А/134 дүгээр захирамжийн дагуу гамшгаас хамгаалах сургалт;
- 2025 оны 06 дугаар сарын 19-нд НДЕГ болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хамтран аймаг, нийслэлийн дүүргүүдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд зохион байгуулсан өмчийн бүртгэл, тооллого тайлагнах тухай сургалт;
- 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр “Шилэн дансний тухай хууль”-ийн талаарх сургалт;
- 2025 оны 07 дугаар сарын 05-нд Салбарын ёс зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сургалт;
- 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 08/1958 дугаар албан бичгийн дагуу Эйблсофт ХХК-аас зохион байгуулсан сургалт;
- 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт” сэдэвт сургалт
- 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сургалт;
- 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр тус газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын тухай” хуулийн сургалт;
- 2025 оны 10 дугаар сарын 19-ны өдөр “Ахмадаас суралцъя, чөлөөт ярилцлага хийх” сургалтыг зохион байгуулсан;
- 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Байгууллагын соёл ба үйлчилгээний чанар” сургалт;

- 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай сургалтыг Хөдөлмөр, халамжийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан;
- 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Монгол бичгийг дижитал орчинд эзэмших нь” сэдвээр Болорсофт, Чимэгэ, Эгүнэ системийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал С.Бадралын сургалт;
- 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдөр Санхүүгийн мэдээллийн технологийн төв, УТҮГ-ийн Санхүүгийн инновац хөгжүүлэлтийн газрын Системийн аналит Э.Энэрэл “Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем”-ийн сургалт;
- 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр НДЕГ, ШШГГ-тай хамтран зохион байгуулсан Хууль зүйн мэдлэг дээшлүүлэх ээлжит сургалт;
- 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр НДЕГ-ын Ёс зүйн дэд хорооноос салбарын нийт Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг оролцуулсан цахим уулзалт;
- 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн мэдээллийн цагаар Засгийн газрын 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”, “Бодлогын баримт бичиг болон байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахад анхаарах асуудал” сэдвээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт Д.Отгон, Үнэлгээ, мониторингийн хэлтсийн ахлах шинжээч Ш.Бумаажав нарын цахим сургалт,
- НДЕГ-ын даргын А/267 дугаар тушаалаар баталсан “Заавар батлах тухай”, “Тэтгэмж бодох заавар”-ыг баталсантай холбогдуулан 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр анхаарах асуудлуудын талаарх сургалт,
- НДЕГ-н Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан ёс зүйн гишүүдийг чадавхжуулах сургалт;
- НДЕГ-аас зохион байгуулсан Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх, Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, хуулийн зорилт, хэрэгжилтийг хангах, байцаагч ажилтнуудыг чадавхжуулах сургалтад 2025 оны 11 дүгээр сарын 12-ноос 27-ны өдрүүдэд цахимаар хамруулсан.

ТАНИЛЦСАН: ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.ДАВААДОРЖ

ТАЙЛАН БИЧСЭН: ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН
ХЭЛСИЙН ДАРГА

Т.ГЭРЭЛТУНГАЛАГ